

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн товч тодорхойлолт	3
ОРШИЛ	5
2. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
Агаарын температур	7
3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	8
3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ.....	8
3.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	8
3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	8
3.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	8
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ТЭР БУМ МОД ХӨТӨЛБӨР	13
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
9. ХИМИЙН БОДИС ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	14
11. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	16
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ	20

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол	3
Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим	5
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах ажил	13
Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	15
Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	17
Хүснэгт 7. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	19
Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	20
Хүснэгт 9. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	21

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч тодорхойлолт

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших “Замын Улаан” нэртэй 010736А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь АМГТХЭГ-ын даргын 2007 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн шийдвэрээр “Оюут бэл” ХХК-д олгогдсон ба 2018 онд “Монгол Перлит Констракшн” ХХК нэр дээр шилжүүлэгдсэн болно. Тус талбайн “Замын улаан” нэртэй ордын хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-н 2009 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж ордын нөөцийг баттай (А) 2274 мян.м³, бодитой (В) 3362 мян.м³, боломжтой (С) нөөц 8455 мян.м³ зэрэглэлээр хүлээлгэн өгч, АМГ-ын газрын даргын 2009 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн №488 тоот тушаалаар нөөцийг хүлээн авч, бүртгэсэн байна. Замын Улааны перлитийн ордыг ил уурхайн аргаар жилд 80000 м³ олборлох хүчин чадалтай. Нийт хөрс хуулалт – 25.6 мян.мз, Перлит олборлолт - 80.0 мян.мз Засаг захиргаа: Дундговь аймаг, Цагаандэлгэр сум

Талбайн нэр: Замын улаан уул


Ашигт малтмалын нэр: Перлит

Талбайн нийт хэмжээ: 103.11 га

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол

Тусгай зөвшөөрлийн талбайн дугаар	Талбайн хэмжээ, га	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
MV-010736	103.11	1	107°43'30"	46°20'0"
		2	107°44'48"	46°20'0"
		3	107°44'48"	46°19'40"
		4	107°43'30"	46°19'40"

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр



Зураг 1. Талбайн байршлын тойм зураг

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

ОРШИЛ

Ил уурхайн хүрэн дэх геологийн нөөцийг ашиглалтын талбайн лицензийн хүрээ болон нөөцийн хүрээгээр хязгаарлаж тооцсон. Ил уурхайн эхний жил буюу 2024 онд тухайн ордын нөөцийн А-2 блокоос голчлон олборлох ба А-3 болон В-7 бага зэрэг нөөцийг олборлохоор тусгалаа.

Уурхайн ажиллах горим, хүчин чадал

Замын Улааны перлитийн уурхайн ажиллах горим болон хүчин чадлыг ТЭЗҮ боловсруулах техникийн даалгаврын дагуу авч, төсөлд тусгав. Замын улааны перлитийн уурхай нь 04 дугаар сарын 20-наас 12 дугаар сарын 30-ныг хүртэл, 2 ээлжээр 24 цагийн үргэлжлэлтэйгээр ажиллана. жилд 80.0 мян.м3 перлит олборлох хүчин чадалтайгаар ажиллана.


Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Жилд ажиллах
1	Ажиллах хугацаа	04 дугаар сарын 20-наас 12 дугаар сарын 30 хүртэл	
2	Жилд ажиллах хуанлын өдөр	хоног	305
3	Баяр ёслолын үеийн амралтын өдөр	хоног	10
4	Засвар үйлчилгээ, цаг агаар болон бусад өдрүүд	хоног	35
5	Уурхайн ажиллах өдөр /бутлах цех/	хоног	260
6	Уулын ажил хийгдэх хугацаа	хоног	90
7	Нэг хоногийн ээлжийн тоо	хоног	2
8	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	11
9	Ээлж солилцох хугацаа	цаг	1

Уурхайн календарьчилсан төлөвлөгөө

Замын Улааны перлитийн уурхайг жилд 80.0 мян.м3 перлит олборлох хүчин чадалтайгаар уурхайн хүрээнд хамаарах үйлдвэрлэлийн нөөцийг бүрэн ашиглана гэж үзвэл уурхайг 109 жил ашиглахаар тооцоо гарч байна. Уурхайг 5 жил тутам тодотгоод явах учир уурхайн календарьт төлөвлөгөөг эхний 10 жилээр авч, үлдсэн нөөцийг тоймлон төсөлд тусгалаа. Уурхай нь эхний жил нөөцийн А-2, А-3, В-7 блокуудаас ашиглах ба 4,5-р сард уурхайн бэлтгэл ажил хийгдэж 6 сараас бүтээгдэхүүн гаргаж эхэлнэ.

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр



Зураг 2. Уурхайн ерөнхий календарчилсан төлөвлөгөө

Уурхайн нээлтийн ажлын хүрээнд эхний жил ашиглах блокуудын хөрсийг зайлуулж, перлитийн таазыг нээж өгөх ажил хийгдэнэ. Уурхайг А-2 блокоос эхлэн ашиглана. Уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн А-2, А-3, А-4 блокуудыг ашиглалтад бэлтгэхэд 7.4 мян.м³ шимт хөрс, 17.7 мян.м³ сэвсгэр хурдас хуулах ажил хийгдэнэ.

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгаль, цаг уур: Дундговь аймаг нь Монгол улсын нутгийн төв хэсэгт талархаг нутагт говь хээрийн бүсийн зааг дээр оршдог. Нутгийн хамгийн өндөр цэг нь 1926 м өндөрт орших Дэлгэрхангай уул юм. Мөн Их, Бага газрын чулуу зэрэг уулс бий. Дундговь аймагт Онгийн голоос өөр том гол, нуур байхгүй. Дундговь аймгийн нутаг нь боржин чулуутай цохио, толгод, бэсрэг уулс бүхий ухаа гүвээрхэг тэгшивтэр нутагт хамаарна. Нийт газар нутгийн талбай 74,690 км квадрат. Далайн түвшнээс дээш 1100-1350 метрт өргөгдсөн байдаг.

Агаарын температур

Дундговь аймгийн агаарын температур ОЖД-аар 1,1-4,7 градусын хооронд хэлбэлздэг байна. Хамгийн хүйтэн 1 дүгээр сард агаарын дундаж температур -16,7 градусаас -19,6 градус байхад агаарын үнэмлэхүй хамгийн бага -39,7 градус 1981 онд Сайхан-овоо өртөөнд ажиглагдсан байдаг. Хамгийн дулаан 7 дугаар сард агаарын температур 19,9 градусаас 22,3 градус байхад агаарын үнэмлэхүй их температур 41,3 градус Гурвансайхан өртөөн дээр 1999 онд ажиглагдсан байдаг байна. Дундговь аймгийн агаарын дундаж температур 2,6 градусаар дулаарсан.

Ургамлын бүрхэвч:

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дундад халхын хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Энэ тойрогт 793 зүйл ургамалтай бөгөөд зөвхөн энэ тойрогт ургадаг 1 зүйл (*Paraver rubro-augantiasum*)ийн ургамалтай.

Ан амьтан:

Цагаандэлгэр сумын нутаг нь байгалийн бүс бүслүүрийн хувьд хуурай хээр, цөлжүү хээрт хамаарна. Тиймээс говь, цөлийн амьтад зонхилон байршина. Амьтны тархалт, тоо хэмжээний хувьд дунд зэрэг. Туурайтнаас намартаа цагаан зээр нүүдэллэн ирдэг. Жигүүртнээс элээ, хэрээ, тас, харцага, тогоруу, ногтруу, шаазгай, шар шувуу, ууль, тагтаа, хэвлээр явагчдаас могой, гүрвэл мэрэгчдээс үлийн цагаан, шар сүүлт, алаг даага, махчин амьтдаас чоно, үнэг, хярс, шавж идэштнээс зараа зэрэг тохиолдоно.

Ус зүй

Хайгуул хийсэн талбайн урд хэсэгт газрын доор 130-140 метрийн гүнд гүний ус байж болох магадлалтай. Орд газрыг бүрдүүлж байгаа перлитийн үе нь газрын доорхи усны төвшнөөс дээр тогтсон учраас ил, далд уурхайгаар перлит олборлох нөхцөлд ус таталт, ус шүүрүүлэлтийн ажил хийх шаардлагагүй. Орд орчимд өрөмдөгдсөн цооногуудаар газрын гүний ус илрээгүй. Байгалийн усны эх булаггүй ба жижиг булгуудаас тэжээгдэх ганц жижигхэн голтой (Замын улаан худаг, Элгэн булаг). Усны хэмжээ нь их биш. Хамгийн том нуур нь Их цагаан нуур, Рашаант нуур бөгөөд ихэнх нуур цөөрөм нь давслаг. Зун намрын үргэлжилсэн борооны үед түр зуурын урсгалтай ус бий болно.

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1.Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ

2024 онд бэлтгэл ажил, уулын ажлын хөрс хуулалт, олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэж агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

3.2.Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

3.3.Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2024 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Ил уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэнэ. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

3.4.Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

Байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих. Стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авах.
- Хөрс хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах.
- Тоосжилт тархах хүрээ ачиж, тээвэрлэх, буулгах газраас 50-100 м орчимд байхаар зам, овоолгын байршлыг оновчтой сонгох, улмаар байнгын ажлын байрнаас зайдуу байршуулах хэрэгтэй.
- Уурхайн дотоод тээвэрлэлтийн авто замуудыг байнга усалж байх, ялангуяа тоосжилт, шороон шуурганы гаралт нэмэгддэг хуурайшилттай хаврын улиралд төслийн талбайг усаар норгох, чийглэх

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

- Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тээвэрлэсэн автомашиныг хучиж, хөрс, тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх.
- Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх.
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх
- Ашиглалтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтсон нэг маршрутын дагуу явуулах, МУ-ын стандартын дагуу замын уулзвар, салаалалт дээр тэмдэгжүүлэх
- Үржил шимт өнгөн хөрсийг хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах
- Уурхайн үйл ажиллагааны явцад боломжтой газруудад нөхөн сэргээлтийг дор дор нь хийж байх
- Үржил шимт хөрсний алдагдал, өгөршлийг бууруулахын тулд хөрсний овоолгыг ургамалжуулах, шимт хөрсийг аль болох богино хугацаанд нөхөн сэргээлтэд ашиглах
- Ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах
- Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авах
- Тоног төхөөрөмжийн шатах тослох материал болон барилгын материалын Төвлөрсөн цэгийг байгуулж, нэвчүүлэхгүй материал ашиглан тохижуулах
- Талбайн хэмжээнд байрлах уст цэгүүдэд тогтмол горимын болон чанарын хяналт шинжилгээг явуулах
- Барилга, байгууламж байршуулсан хэсэгт үерийн ус зайлуулах шуудуу татах
- Шатах тослох материал, алдагдах, асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Уурхайн дотоод, гадаад тээврийн үйл ажиллагаанаас үүсэх орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг ашиглахаас аль болох зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах
- Тоосны ялгаралтыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгахын тулд байнгын хяналттай ажиллах зэрэг арга хэмжээг авч ажиллана

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газар, БОАЖЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу “МОНГОЛ ПЕРЛИТ КОНСТРАКШН” ХХК-ийн “Замын улаан” перлитийн ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав. Төсөл хэрэгжүүлэгч “МОНГОЛ ПЕРЛИТ КОНСТРАКШН” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагааны сөрөг нөлөөллөө байгальд үзүүлж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлж ажиллана.

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	1	2	3	4	5	6	9
1	Агаарын чанар Салхины хурд 10 м/с үед тээвэрлэлтийн замаас үүсэх тоосонцрын агууламж стандарт хэмжээнээс давж болзошгүй	Уурхайн дотоод зам талбайг услах	Тоос босох гадаргуу	Мот/цаг	2000000	Төслийн хугацаанд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 MNS 3384:82
		Уурхайд ажиллаж байгаа машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч бүхээгт тоос орохгүй болгох арга хэмжээ авч байх	Уурхайн бүх авто машинуудад	-	-	2024 он	
		Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Уурхайн хэмжээнд	-	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон	2024 он	
		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	-	Уулын ажлын зардалд орсон	2024 он	
Нийт		2000000					
2.	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө			1000000	2024 он	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008
		Уурхайгаа тойруулан үерийн далан байгуулах	Үйл ажиллагааны зардалд орно			2024 он	

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

		Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Уст цэгт	Зардал нь хяналт шинжилгээний зардалд орсон		2024 он	
	Нийт	1 000 000					
3.	Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Уурхайн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардалд	2024 он	MNS 5916:2008 MNS 5917:2008
		Автомашинны зогсоолыг цементэн хучилттай болгох	Засварын талбай, авто зогсоол	-	1000000	2024 он	MNS 5918:2008
		Шимт хөрсний нөөц бий болгох стандартын дагуу овоолж, хадгалах	Шимт хөрс	10.4м³	1000000	2024 он	
		Ажилчдын хотхоны бие засах газрыг Байгаль орчинд ээлтэй эко 00 барих	Уурхайн хотхонд		2000000		
	Нийт	4000000					
4	Ургамлан нөмрөг болон Амьтны аймаг	Олон салаа зам гаргахгүй байна. Замын тэмдэг тэмдэглэгээ байршуулна	Уурхайн зам, уурхайн хил хязгаар	-	1000000	Төслийн хугацаанд	Амьтны тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай
		Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байрлуулна.	Уурхайн хотхонд	-	1000000	2024 он	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
	Нийт	2000000					
5	Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал 9 000 000						

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Техникийн нөхөн сэргээлт

2024 онд 0.75 га талбайд 31 м3 гадаад овоолго үүснэ. Тус онд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй. Ордын олборлолт эхлэх үед шимт хөрсийн 0.2 м зузаантай хуулж, биологийн нөхөн сэргээлтэд ашиглах нөөц бий болох бөгөөд талбайн зүүн урд нөөц бодогдоогүй хэсэгт 300 м зайд овоолго үүсгэн стандартын дагуу хадгална.

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ТЭР БУМ МОД

ХӨТӨЛБӨР

“Монгол перлит констракшн” ХХК нь 2024 онд орон нутгаас заасан чиглэлд дүйцүүлэн хамгаалах ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөв.

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах ажил

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Сумын нутаг дэвсгэрт орон нутгаас заасан чиглэлийн дагуу	-	-	-	-	8000000	2024 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
	Сум орон нутгийн заасан талбайд 500ш мод			500ш		2000000	2024 онд	
	Нийт					10 000 000		

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

9. ХИМИЙН БОДИС ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийнхамрах хүрээ	Хэмжихнэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог Хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг сумын ТҮК-тэй гэрээ байгуулан зөөвөрлөх	Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нэгдсэн хогийн цэгт хогоо нийлүүлэх,	кг	-	-	Уурхайн дотоод зардалд орсон.	Хог хаягдлын тухай хууль
		Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна.	Ажилчдын байрны гадна байршуулах	тоо	100 000	3	300 000	
		Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Хог хаягдлын цэг	М ²	500 000	0.3	500 000	
2	Аюултай хог хаягдал	Машинаас гарсан хаягдал, гос масло болон гарсан дугуй, гэрлийн шил, бусад сэлбэгийн хог хаягдал, хуванцар сав зэргийг ангилан ялгаж, хаягдал боловсруулах үйлдвэр, дахивар авах цэгт нийлүүлэх	Уурхайн талбайд	тоо	300 000	-	200 000	
Нийт зардал					1 000 000			

11. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГ

Аянга цахилгаан: Дулааны улиралд тохиолдох бөгөөд цаг агаарын мэдээг тогтмол мэдээлэх хэрэгтэй. Цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх, ил задгай цахилгааны утас зэрэг аянга үүсэж болзошгүй зүйлүүдийг хамгаалах

Газар хөдлөлт: Газар хөдлөлтийн мужлалаар төсөл хэрэгжих газар нь 6 баллын бүсэд хамаарна. Иймээс барилга байгууламж барихдаа зураг төслийн дагуу эрсдэлийг нарийвчлан авч үзэх шаардлагатай. Мөн ашиглалтын явцад газар хөдлөлтийн үед авах арга хэмжээг боловсруулах. Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бийболгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх.

Шороон шуурга: Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бийболгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх Халдварт өвчин: Уурхайн ажилчдад хууль бус ан агнахгүй байх түүнээс үүдэн гарах сөрөг нөлөөллийн талаар сургалт явуулах, хамгаалалтын хэрэгслээр хангах (амны хаалт г.м), аймгийн эрүүл мэндийн төвтэй харилцаа холбоотой байж мэдээлэл авч байх

Гал түймэр: Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа, хяналтын ажил, гал гарсан үед түүнийг унтраах хэрэгслийн хангамж, цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллах үд мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг МУ-н “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Аж ахуй нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”, “Гал түймрийн аюулгүй байдалтай холбогдуулан гаргасан тушаал, шийдвэрийн дагуу зохион явуулна

Авто тээврийн осол: Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчдын аюулгүй ажиллагааны сургалтад тогтмол хамруулах. Уурхайн зам тээвэрт хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг сайн хийх, замын хөдөлгөөний аюулгүй дүрмийг чанд баримтлан ажиллах.

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР


“Монгол перлит констракшн” ХХК-ийн “Замын улаан” нэртэй перлитийн орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээний локаль мониторингийн систем байгуулах нь зүйтэй. Мониторингийн цэгийг зөв сонгож, хугацаа, давтамж зэргийг нь оновчтой сонгож өгөх нь чухал юм. Тус төслийн орчимд явуулбал зохих экологийн хяналтын мониторингийн ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, мониторингийн ажлын давтамж, хэмжилт судалгааны ажлыг хариуцах мэргэжилтэн, мониторингийн үзүүлэлт зэргийг доорх хүснэгтэд тусган оруулж өгөв.

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

ШИНЖ ИЛГЭЭ ХИЙХ ҮЗҮҮЛ	Хэмжих нэгж	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар	Тоосонцор: TSP, PM2.5, PM10	1 удаа	-	-	MNS 4585:2016
	SO _x NO _x CO _x цацраг болон бусад		80.0	160.0	MNS 6063:2010 MNS 5002:2000 MNS 3113:1981 MNS 5885:2008
	Дуу чимээ чичиргээ, доргио		-	-	Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
	Нийт зардал			160.0	
Хөрсөн бүрхэвч	- Механик бүрэлдэхүүн - Хими, физикийн шинж чанар - Бохирдол - Хүнд металл /Pb, Cd, Hg, As, Cr,.../ - Нефтийн бүтээгдэхүүн - Бактереологи	1 удаа	65.0	130.0	MNS 5850 : 2008 MNS 3298 : 1991 MNS 5546 : 2005 MNS 3985 – 87 MNS 2305 - 94
	Нийт зардал			130.0	
Ус	- Хүнд металл - Анион, катион - Бактереологи - Худаг, цооногуудын усны түвшин, түүний өөрчлөлт	1 удаа	20.0	60.0	MNS 3934:1986 MNS /ISO/ 5667-11:2000 MNS / ISO / 5667-11:2000 MNS 6148:2010 MNS 5667:10:2001 MNS 6148:2010 MNS /ISO/ 5667-11:2000 MNS 3934:1986 MNS /ISO/ 5667-11:2000 MNS 4943:2011 MNS 900:2005 Усны тухай хууль
	Нийт зардал			60.0	
	Орчны хяналт шинжилгээний тайлан боловсруулах зардал	1 удаа		3000.0	
НИЙТ ЗАРДАЛ				3350.0	

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр



Зураг 3. Мониторингийн байршлын зураг

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж ажиллана.

Хүснэгт 7. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ажилчдын мэдлэг чадвар дутмаг байдлаас ажлын доголдол гарах	Уурхайд ажиллаж байгаа ажиллагсдын тухайн ажлыг хийж гүйцэтгэх мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургаалтанд хамруулж байх	Ажилчид	1000000	Жил бүр	МУ-ын үндсэн хууль Хөдөлмөрийн тухай Эрүүл мэндийн тухай Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм MNS 4990:2000 MNS 4968:2000 MNS 4994:2000
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх		Тусгай зөвшөөрлийн талбайд	8000000		
Уул уурхайн үйл ажиллагаанаас ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй	Ажлын байрны хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилчдыг илчлэг, витаминлаг хоол хүнсээр хангах	Бүх ажилчдыг	Үйл ажиллагааны зардалд орсон	Өдөр бүр	
			9000000		

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Төслийн талбайн ойролцоох иргэд болон төсөл хэрэгжиж буй баг, сонирхогч талууд, засаг захиргааны ажилчид	Төслийн талаарх мэдээллийг цаасан болон presentation хэлбэрээр тайлагнах, хэлэлцэх	Төслийн нөөц, ашиглалтын техник технологи, ажилчид, бусад үйл ажиллагааны талаарх мэдээлэл, төслөөс байгаль орчин болон нийгэм эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах багасгах чиглэлээр хийсэн арга хэмжээ, байгаль хамгаалах, дүйцүүлэн хамгаалах чиглэлээр хийсэн, нөхөн сэргээлтийн ажлын тухай	Жилд 1 удаа. 10-11 сард.	Төслийн үйл ажиллагаагаар уурхайн ойролцоох малчдын амьдрал ахуй, эрүүл мэнд, нийгэмд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөө, сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах чиглэлээр хэрэгжүүлбэл зохистой арга хэмжээ, төслийн үйл ажиллагааны талаарх санал бодлыг сонсох	Багийн эсвэл сумын төв
Зардал, мян.төг					500000

БОМТ-ний биелэлтийн тайланг тухайн оны 12 сарын 10-ний дотор БОАЖЯаманд ирүүлэх ба үүнээс өмнө хуваарийн дагуу орон нутгийн иргэд, засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчид, сонирхогч талуудад танилцуулж хэлэлцүүлэн тэдний санал бодлыг тайланд тусгасан байна.

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших MV-010736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын улаан” нэртэй перлитийн ордын 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

Хүснэгт 9. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	9000.0
2	Тэр бум мод ажлын зардал	2000.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	8000.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1000.0
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3350.0
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1300.0
8	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	9000.0
9	2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	33650.0

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нөхөн сэргээх арга хэмжээнд нийт **33.65 сая** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Үүний 50 хувь 16.82 сая төгрөг байна. Бид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.